



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.24 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гендекс ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Чойжилсүрэн овогтой Бат-Өлзийг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 121 дүгээр тушаалаар томилогдсон Эрдэнэтуяа овогтой Төгөлдөрийг томилсон зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсугай.


3. Гүйцэтгэх захирлыг өөрчлөн томилсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Гендекс ҮЦК” ХХК /Ч.Бат-Өлзий/-д үүрэг болгосугай.

1/ Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;

2/ Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН